



**ГОВЬСҮМБЭР АЙМАГ  
ШИВЭЭГОВЬ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ**

2024 оны 06 сарын 17 өдөр

Дугаар 1176

Шивээговь сум

“Төрийн байгууллагуудад шаардлагатай  
техник, тоног төхөөрөмж худалдан авах”  
ажлыг хүлээж авах комисс томилох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1.2, 66 дугаар зүйлийн 66.1, Захиргааны ерөнхий хуулийн 43 дугаар зүйлийн 43.1, 46 дугаар зүйлийн 46.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.12, Сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2023 оны 12 дугаар сарын 19-ний өдрийн 06 дугаар “Сумын 2024 оны төсөв батлах тухай” тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:

1.Сумын 2024 оны Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр худалдан авч буй “Төрийн байгууллагуудын шаардлагатай техник, тоног төхөөрөмж худалдан авах ажил”-ыг хүлээж авах комиссыг дараах бүрэлдэхүүнтэй томилсугай.

Комиссын дарга:

Л.Бадамханд

(Засаг даргын орлогч)

Гишүүд:

Д.Отгонжаргал

(Засаг даргын Тамгын газрын дарга)

Ж.Баярцэцэг

(Ерөнхий боловсролын сургуулийн  
Сургалтын менежер)

Ц.Туул

(3-р цэцэрлэгийн Арга зүйч)

Х.Сувданцэцэг

(Эрүүл мэндийн төвийн 1-р багийн их  
эмч)

Л.Түмэнцэцэг

(Соёлын төвийн Бүжгийн багш)

М.Гантуяа

(Хууль, эрх зүй хариуцсан  
мэргэжилтэн)

А.Баасанхүү

(Иргэдийн төлөөлөгчидийн хурлын  
Хяналтын бүлгийн гишүүн)

Нарийн бичгийн дарга:

Д.Баттуул

(Хөрөнгө оруулалт, эдийн засаг төлөвлөлт, худалдан авах ажиллагаа хариуцсан мэргэжилтэн)

2. Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр худалдан авч буй “Төрийн байгууллагуудын шаардлагатай техник тоног төхөөрөмж худалдан авах ажил”-ыг хүлээн авч ашиглалтад оруулах ажлыг хууль тогтоомжийн дагуу зохион байгуулж, үр дүнг танилцуулж ажиллахыг комиссын дарга (Л.Бадамханд)-д, өмч хөрөнгийг бүртгэлжүүлэх ажлыг зохион байгуулж, хяналт тавьж ажиллахыг Хөрөнгө оруулалт, эдийн засгийн төлөвлөлт, худалдан авах ажиллагаа хариуцсан мэргэжилтэн (Д.Баттуул)-д, өмч хөрөнгийг зориулалтын дагуу ашиглаж, үр ашгийг дээшлүүлэн, ашиглалт хамгаалалтыг хариуцан ажиллахыг байгууллагын дарга нарт тус тус үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА

Ч.СУГАРМАА

